

## **Коронавирусын эсрэг вакциныг хэрэглэх заавар**

### **Коронавирусын эсрэг вакцины тухай**

Энэхүү вакцин нь үндэсний болон орон нутгийн засаг захиргааны коронавирусын (SARS-CoV-2) эсрэг вакцинжуулалтын хөтөлбөрийн нэг хэсэг юм. Энэхүү вакцинжуулалтыг Засгийн газраас санхүүжүүлж байгаа бөгөөд хүссэн хүн бүр үнэ төлбөргүй хамрагдах боломжтой. Уг вакцин нь 12 ба түүнээс дээш насны хүмүүст зориулагдсан.

### **Вакцины үр нөлөө, ашиглах арга**

Энэхүү вакциныг “Pfizer” компани үйлдвэрлэсэн ба коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

Вакцинжуулалтад хамрагдсан хүмүүсийг хамрагдаагүй хүнтэй харьцуулахад маш бага тоогоор коронавирусын халдварт өвчин тусч байгааг баталсан. (тус вакцин нь өвчнөөс урьдчилан сэргийлэх чадвар ойролцоогоор 95% гэж мэдээлсэн).

Худалдааны нэр	Булчинд тарих Comirnaty®
Үр нөлөө	SARS-CoV-2-ээс үүдэлтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
Вакцинжуулалтын давтамж ба хоорондын зай	2 удаа (ихэвчлэн 3 долоо хоногийн зайтай) * Булчинд тарих
Вакцинжуулалтын хамрах хүрээ	12 ба түүнээс дээш насны хүн (12-оос доош насны хүнд үзүүлэх үр нөлөө, аюулгүй байдлыг хараахан тогтоогоогүй байна.)
Тарилгын тоо, тун	нэг тун 0.3 мл; нийт 2 удаа

- Эхний вакцины тунг тарьснаас хойш 3 долоо хоногийн дараа хоёр дахь тунг тарина. (Эхний тунг тарьснаас хойш 3 долоо хоногоос хэтэрвэл хоёр дахь тунгаа аль болох хурдан тариулна уу.)
- Хэрэв та тус вакцины эхний тунг хийлгэсэн бол тус вакцины хоёр дахь тунг үндсэндээ хийлгэх учиртай.
- Тус вакцины хоёр дахь тунг хийснээс хойш ойролцоогоор 7 хоногийн дараа хангалттай дархлаа тогтоно гэж үзэж байгаа. Мөн халдвараас бүрэн хамгаална гэсэн үг биш юм. Вакцинд хамрагдсан эсэхээс үл хамааран халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хийх ёстой.

### **Вакцинжуулалтад хамрагдах боломжгүй хүн**

Энэ вакциныг доорхи хүмүүст хийх боломжгүй. Вакцин хийлгэхээс өмнөх үзлэгийн үед доорхи нөхцлүүд танд хамаатай гэж бодож байвал эмчид заавал мэдэгдэнэ үү.

- Илт халуурах шинж тэмдэгтэй хүн (\*1)
- Хүнд цочмог өвчтэй хүн
- Энэ вакцины аль нэгэн найрлагад хэт их мэдрэг (\*2) өвчний түүхтэй хүн
- Дээрхээс гадна вакцин хийлгэхэд биеийн байдал тохиромжгүй хүн

(\*1) 37.5°C ба түүнээс дээш халуурч байвал илт халуурах шинж тэмдэгтэй гэж тодорхойлно. Гэвч, 37.5°C -ээс бага байсан ч энгийн үеийн биеийн халуунаас их байвал халуурч байна гэж үзнэ.

(\*2) Анафилаксийн шок болон бүх биеийг хамарсан арьс, салстан бүрхэвчээр туурах, амьсгаадах, амьсгал давчдах, зүрхний хэм алдагдах, цусны даралт буурах зэрэг харшлын шинж тэмдэг орно.

### **Вакцин хийлгэхдээ анхаарах хэрэгтэй хүн**

Дараах шинж тэмдэг илэрдэг хүмүүс энэ вакциныг хийлгэхдээ анхаарах хэрэгтэй. Вакцин хийлгэхээс өмнө үзлэг хийх үед доорхи шинж тэмдэг танд хамаатай гэж бодож байвал эмчид заавал мэдэгдэнэ үү.

- Антикоагулянт эмчилгээ хийдэг, тромбоцитопени буюу цус бүлэгнэлтийн эмгэгтэй
- Өмнө нь дархлал хомсдол гэж оношлогдсон, эсвэл төрөл төрөгсөд нь удмын дархлал хомсдолын өвчтэй хүн байгаа бол
- Зүрх, бөөр, элэг, цус, хөгжлийн гажиг зэрэг суурь өвчтэй
- Өмнө нь вакцин хийлгэсний дараа 2 хоногийн дотор харшлын шинж тэмдэг, тухайлбал халуурах, тууралт гарах зэрэг шинж тэмдгүүд илэрч байсан бол
- Таталт өгдөг, өгч байсан бол
- Тус вакцины найрлагад харшилтай байж болзошгүй бол

Хэрэв та жирэмсэн эсвэл жирэмсэн байж болзошгүй, эсвэл хөхүүл хүүхэдтэй бол вакцин хийлгэхээс өмнө эмчид заавал мэдэгдэнэ үү

Энэ бүтээгдэхүүн нь урьд өмнө байгаагүй нэмэлт бодис агуулдаг. Хэрэв та өмнө эмэнд хэт мэдрэг эсвэл харшлын урвал үзүүлж байсан бол урьдчилсан үзлэгийн үеэр энэ талаар эмчид заавал мэдэгдэнэ үү

**(Ар талд нь үргэлжлэлийг үзнэ үү)**

## Вакцин хийлгэсний дараа анхаарах зүйлс

- Вакцин хийлгэсний дараа доод тал нь 15 минут хүлээнэ үү (өмнө нь харшлын шинж тэмдэг, түүний дотор анафилаксийн шок гэх мэт хүнд хэлбэрийн өвчнөөр өвчилж байсан, эсвэл бие тавгүйрхэж, ухаан алдаж унаж байсан гэх мэт хүн дор хаяж 30 минут хүлээнэ үү). Хэрэв бие тавгүйрхвэл эмчид яаралтай хандах хэрэгтэй. (Энэ нь гэнэтийн хариу урвалд яаралтай арга хэмжээ авах боломжийг олгоно.)
- Тарилга хийх хэсэг цэвэр байх ёстой. Хэдийгээр та вакцин хийлгэсэн өдөр усанд орж болох ч тарилга хийсэн хэсгийг үрж угааж болохгүй.
- Тарилга хийх өдөр хүчтэй дасгал сургуулилалт хийхээс татгалзаарай.

## Гаж нөлөө

- Ихэнхи гаж нөлөөнд тарилга хийсэн газар өвдөх, толгой өвдөх, үе мөч, булчин өвдөх, ядрах, даарах, халуурах зэрэг орно. Ховор бөгөөд ноцтой гаж нөлөөнд шок эсвэл анафилаксийн шок орно. Одоогийн вакцин нь шинэ төрлийн вакцин тул хараахан тодорхой болоогүй шинэ шинж тэмдэг илэрч болзошгүй юм. Хэрэв вакцин хийлгэсний дараа ямар нэг шинж тэмдэг илэрвэл вакцинжуулагч эмч эсвэл хариуцсан эмчтэй холбоо бариарай.
- Маш ховор тохиолдолд вакцин хийлгэсний дараа хөнгөн хэлбэрийн зүрхний булчингийн үрэвсэл болон зүрхний үнхэлцгийн үрэвсэл үүссэн талаар мэдээлсэн (\*). Вакцин хийлгэсний дараа хэд хоногийн дотор цээжээр өвдөх, зүрх дэлсэх, амьсгал давчдах, хавагнах зэрэг шинж тэмдэг илэрвэл эрүүл мэндийн байгууллагад яаралтай хандаарай.  
(\*). Энэ нь эхний тунгаас илүү 2 дахь тунг хийлгэсний дараа их тохиолдох бөгөөд залуучууд ялангуяа эрэгтэй хүмүүст их тохиолодох хандлагатай байна.

## Вакцины эрүүл мэндэд үзүүлэх хор хөнөөлийг бууруулах системийн талаар

Вакцинжуулалт нь эрүүл мэндийн асуудал (өвчин, хөгжлийн бэрхшээл) үүсгэх магадлалтай. Энэ нь нэн ховор боловч эрсдлийг арилгах боломжгүй юм. Тиймээс тусламжийн системийг бий болгосон.

Коронавирусын эсрэг вакцины улмаас эрүүл мэнд хохирсон тохиолдолд дархлаажуулалтын тухай хуулийн дагуу тусламжийг (эмчилгээний зардал, тахир дутуугийн тэтгэвэр гэх мэт) олгогдоно. Өргөдөл өгөх талаар оршин суугаа хотын захиргаанаасаа лавлана уу.

## Коронавирусын халдварын тухай

SARS-CoV-2 халдварын үед шинж тэмдгүүд нь халуурах, ханиалгах зэрэг нийтлэг ханиадны шинж тэмдгүүдтэй төстэй байдаг. Ихэнх хүмүүс тус өвчний хөнгөн шинж тэмдгээр тусаж эдгэрдэг боловч хүнд тохиолдолд амьсгал давчдах зэрэг уушгины хатгалгааны шинж тэмдэг илэрч, нөхцөл байдал улам муудаж, улмаар үхэлд хүргэх аюултай.

## Коронавирусын вакцины тодорхойлолт (Pfizer компанийн вакцин)

Энэхүү вакцин нь РНК-мессенжер (мРНК)-ийн вакцин бөгөөд SARS-CoV-2 холболтын үндсэн уураг (вирус хүний эсэд нэвтрэх шаардлагатай уураг) болох липидийн мембран дотор оруулсан мРНК-ийг агуулдаг. мРНК-ийг хүний эсэд оруулахад мРНХ-ийн үндсэн дээр эсүүдэд вирусын холболтын уураг үүсэж, холбох уураг болон эсийн дархлааны хариу урвалын эсрэг биетүүдийг үүсгэдэг бөгөөд энэ нь SARS-CoV-2-ийн халдвараас урьдчилан сэргийлдэг гэж үздэг байна.

Энэхүү эмийн хэрэгсэл нь дараах найрлагатай

Идэвхтэй найрлага	◇ Тозинамеран (хүний эсийн мембрантай холбогддог бүтэн хэмжээний холбох уургийг кодчилдог мРНК)
Нэмэлт	◇ ALC-0315: [(4-гидроксипутил) азандил] бис (гексан-6,1-диил) бис (2-гексилдеcanoат) ◇ ALC-0159: 2 - [(полиэтилен гликол) -2000] -N, N-дитетрадецилацетамид ◇ DSPC: 1,2-дистеоройл-сп-глицеро-3-фосфохолин ◇ Холестерол ◇ Калийн хлорид ◇ Нэг суурьт калийн фосфат ◇ Натрийн хлорид ◇ Хоёр суурьт натрийн фосфатын дигидрат ◇ Сахароз

Коронавирусын эсрэг вакцины үр нөлөө, аюулгүй байдлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны вэбсайта дахь Шинэ төрлийн коронавирусын вакцин хуудаснаас үзнэ үү.

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, коронавирусын эсрэг шинэ вакцин

Хайх



Хэрэв та вэбсайтаа үзэх боломжгүй бол хотын захиргаатай холбоо бариарай.